

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийтийн тээврийн бодлогын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/606/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: bold@audit.gov.mn	
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 11327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn	
	Аудитын менежер: Утас: 11325558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn	С.Гантөгс
	Цахим аудит ХХК-ийн захирал: Утас: 88501881 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com	Л.Амарзаяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

ᠮᠠᠨᠠ. ᠔ᠯ. ᠒᠕ № ᠐᠙/᠒᠔᠓
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН
ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА
Д.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийтийн тээврийн бодлогын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийтийн тээврийн бодлогын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 5,263.2 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 20 дугаар зүйлийн 20.2.5 дах заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн парк шинэчлэл хийх ажлын хүрээнд их багтаамжийн автобус нийлүүлэх тендерт БНХАУ-ын Юутонг бус ХХК шалгарч, гэрээг Нийслэлийн засаг даргын тамгын газартай байгуулсан бөгөөд захиалагчийн төлөөлөгчөөр тус газрыг оролцуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг дамжуулан шилжүүлсэн байна. Нийлүүлсэн автобусыг төлбөр хийсэн байгууллагад бус Нийслэлийн засаг даргын тамгын газарт бүртгэж авсан байгаа нь нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөх зарчмын “уялдаатай байх” зарчимд нийцэхгүй байна.

02003700

Аудитын гол асуудал

Төсвийн шууд захирагч нь тайлант оны бараа, ажил үйлчилгээг батлагдсан төсвийн хүрээнд зардлын ангилал бүрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Бусад асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн автобусны буудлын эцсийн зогсоолын тохижилтыг 3 компаниар гүйцэтгүүлж, нийт 1,138.2 сая төгрөгөөр данс бүртгэлд тусгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	276,744,121,784.70	290,253,007,524.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	89,422,776,250.00	484,050,200.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	89,422,776,250.00	484,050,200.00
31210	Төгрөг	89,422,776,250.00	484,050,200.00
31211	Төрийн сангийн харилцах	89,422,776,250.00	484,050,200.00
33	АВЛАГА	12,952,170,323.70	173,661,931,583.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,277,052.00	1,410,801.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0	149,801,331,373.00
33500	Бусад авлага	12,949,893,271.70	23,859,189,409.00
33510	Байгууллагаас авах авлага	12,949,893,271.70	23,859,189,409.00
34	УРЬДЧИЛГАА	51,449,413,500.00	23,891,066,721.04
34600	Урьдчилж гарсан зардал	51,449,413,500.00	23,514,419,350.00
34710	Урьдчилгаа тооцоо	0	376,647,371.04
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0	376,647,371.04
35	БАРАА МАТЕРИАЛ	299,473,811.00	313,553,420.00
35100	Түүхий эд материал	685,840.00	4,041,260.00
35110	Тусгай зориулалттай материал	0	3,355,420.00
35130	Эм боох материал	685,840.00	685,840.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	0	261,600.00
35400	Хангамжийн материал	298,787,971.00	309,250,560.00
35410	Бичиг хэргийн материал	16,179,349.00	27,234,535.00
35420	Аж ахуйн материал	8,555,542.00	8,555,542.00
35430	Сэлбэг хэрэгсэл	23,713,700.00	17,890,993.00
35440	Түлш, шатах тослох материал	31,082,291.00	17,136,169.00
35470	Бусад хангамжийн материал	219,257,089.00	238,433,321.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	122,620,287,900.00	91,902,405,600.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	122,620,287,900.00	91,902,405,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,987,993,654.19	3,874,353,934.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,987,993,654.19	3,874,353,934.05
39200	Биет хөрөнгө	1,827,058,195.88	3,261,168,975.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,685,968,166.00	1,997,440,756.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-196,736,304.00	-295,712,034.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	526,517,598.00	598,438,283.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	-423,882,791.00	-332,685,600.76
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,439,553,917.14	1,688,269,969.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,214,002,748.13	-1,266,102,416.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,309,403.95	157,502,311.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	-82,929,046.08	-78,724,848.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	28,824,000.00	855,530,076.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-27,564,000.00	-62,787,520.47
39300	Биет бус хөрөнгө	160,935,458.31	613,184,958.27
39301	Программ хангамж	15,604,863.33	457,201,863.33
39302	Хуримтлагдсан элэгдэл	-13,695,905.02	-15,043,405.06
39303	Бусад биет бус хөрөнгө	159,026,500.00	171,026,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	278,732,115,438.89	294,127,361,558.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,214,669,787.64	155,426,932,537.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,882,076,802.03	151,084,339,551.73
41300	Өглөг	2,882,076,802.03	151,084,339,351.73
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	1.65
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	574,077,448.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,421,601,245.08	150,026,171,927.08
41360	Бусад өглөг	1,460,475,556.95	484,090,175.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,459,700,295.00	484,049,975.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	775,261.95	40,200.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,332,592,985.61	4,342,592,985.61
42200	Урт хугацаат зээл	12,332,592,985.61	4,342,592,985.61
42210	Төгрөг	12,332,592,985.61	4,342,592,985.61
42214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	12,332,592,985.61	4,342,592,985.61

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	263,517,445,651.25	138,700,428,920.75
51	Засгийн газрын хувь оролцоо	263,517,445,651.25	138,700,428,920.75
51100	Засгийн газрын оруулсан капитал	505,114,008.39	505,114,008.39
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0	0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	505,114,008.39	505,114,008.39
51200	Хуримтлагдсан үр дүн	263,012,331,642.86	138,195,314,912.36
51210	Өмнөх үеийн үр дүн	55,701,588,795.75	278,992,331,642.86
51220	Тайлант үеийн үр дүн	207,310,742,847.11	-140,797,016,730.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	278,732,115,438.89	294,127,361,558.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	479,009,110,482.77	472,139,692,822.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,907,558,518.87	100,373,836,896.74
120	Нийтлэг татварын бус орлого	1,907,558,518.87	100,373,836,896.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,838,386,558.87	6,409,154,267.01
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,233,581,260.87	5,760,147,399.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	604,805,298.00	649,006,868.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	69,135,000.00	2,060,547,591.73
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	36,960.00	91,904,135,038.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477,101,551,963.90	371,765,855,926.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	128,015,653.00	2,176,981,181.92
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	519,862,966.97
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,279,653.00	332,375,714.95
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,736,000.00	1,324,742,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	195,280,911,919.23	317,506,266,703.32
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	195,280,911,919.23	317,506,266,703.32
1330	Төсвийн захирагчдаас	281,692,624,391.67	52,082,608,041.00
133003	Хөрөнгийн	281,692,624,391.67	52,082,608,041.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	195,237,821,781.86	326,116,552,704.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	195,237,821,781.86	326,116,552,704.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,788,924,243.86	9,185,312,047.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,807,763,174.66	4,109,830,985.29
210101	Үндсэн цалин	1,650,532,985.66	2,127,661,230.96
210102	Нэмэгдэл	487,671,424.00	872,305,034.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	321,134,000.00	795,441,950.00
210104	Урамшуулал	348,424,765.00	314,422,770.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	342,808,848.80	493,098,441.67
210201	Тэтгэврийн даатгал	238,515,399.79	343,882,568.19
210202	Тэтгэмжийн даатгал	27,989,253.71	40,819,616.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,353,600.51	21,410,969.53
210204	Ажилгүйдлийн даатгал	4,888,252.01	17,103,576.27
210205	Эрүүл мэндийн даатгал	49,062,342.78	69,881,711.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,164,525.08	39,215,040.20
210301	Гэрэл, цахилгаан	10,099,715.91	3,451,711.88
210302	Түлш, халаалт	16,380,000.00	7,862,595.20
210303	Цэвэр, бохир ус	110,946.00	677,902.65
210304	Байрны түрээс	38,573,863.17	27,222,830.47
2104	Хангамж, бараа материалын зардал	98,044,335.81	157,860,958.01
210401	Бичиг хэрэг	23,077,736.00	37,447,244.00
210402	Тээвэр, шатахуун	35,491,398.00	61,962,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,713,872.81	28,057,556.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	0

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,725,170.00	1,996,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	0
210408	Бараа материал акталсны зардал	10,536,159.00	28,397,358.00
2105	Нормативт зардал	1,877,990.00	4,207,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	194,990.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,683,000.00	4,207,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,205,850.00	100,814,107.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	787,400.00	372,900.00
210604	Урсгал засвар	16,418,450.00	100,441,207.00
2107	Томилолт, зочны зардал	0	323,947,651.00
210701	Гадаад албан томилолт	0	134,689,301.00
210702	Дотоод албан томилолт	0	189,258,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	178,588,650.00	1,512,618,624.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	122,931,083.00	21,842,530.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	30,400,000.00	12,800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	836,460.00	1,458,732,043.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	555,504.00	975,538.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	97,650.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,420,000.00	3,894,000.00
210807	Газрын төлбөр	5,102,793.00	10,115,033.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.00	160,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,185,160.00	3,859,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	277,470,869.51	2,443,718,739.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	2,122,440,865.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	1,650,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	277,470,869.51	319,627,873.94
212	ТАТААС	191,306,339,061.00	314,770,491,962.01
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	29,090,115,176.00	33,575,557,046.51
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	29,090,115,176.00	33,575,557,046.51
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	162,216,223,885.00	281,194,934,915.50
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	162,216,223,885.00	281,194,934,915.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142,558,477.00	2,160,748,695.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,948,457.00	121,960,833.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	101,288,457.00	89,900,833.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,660,000.00	32,060,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,610,020.00	2,038,787,862.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,806,000.00	2,038,787,862.01
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	12,804,020.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	283,771,288,700.91	146,023,140,118.43
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	2,765,066.00
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0	2,765,066.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	76,460,545,853.80	286,822,921,914.93
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	88,000.00	29,074,534.93
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	76,460,457,853.80	286,793,847,380.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	207,310,742,847.11	140,797,016,730.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	444,358,773,954.77	386,131,920,460.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,877,509,890.87	15,524,433,229.01
120	Нийтлэг татварын бус орлого	89,877,509,890.87	15,524,433,229.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	89,877,509,890.87	15,524,433,229.01
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,232,308,760.87	15,356,570,520.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	88,645,201,130.00	167,862,709.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	354,481,264,063.90	370,607,487,231.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	128,015,653.00	1,018,612,486.92
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	519,862,966.97
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,279,653.00	459,092,019.95
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,736,000.00	39,657,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	195,280,911,919.23	317,506,266,703.32
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	195,280,911,919.23	317,506,266,703.32
1330	Төсвийн захирагчдаас	159,072,336,491.67	52,082,608,041.00
133003	Хөрөнгийн	159,072,336,491.67	52,082,608,041.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	196,770,665,553.10	324,622,084,852.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	196,770,665,553.10	324,622,084,852.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,550,465,444.10	8,052,511,547.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,808,013,158.69	4,110,938,634.98
210101	Үндсэн цалин	1,650,590,530.69	2,128,183,371.40
210102	Нэмэгдэл	487,671,424.00	873,104,412.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	321,134,000.00	795,307,430.58
210104	Урамшуулал	348,617,204.00	314,343,421.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	342,897,865.52	492,756,095.58
210201	Тэтгэврийн даатгал	238,492,126.67	343,499,826.39
210202	Тэтгэмжийн даатгал	28,043,095.74	40,799,816.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,353,600.86	21,504,156.64
210204	Ажилгүйдлийн даатгал	4,891,658.20	17,096,976.29
210205	Эрүүл мэндийн даатгал	49,117,384.05	69,855,320.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,837,139.08	40,615,586.20
210301	Гэрэл, цахилгаан	9,772,329.91	4,852,257.88
210302	Түлш, халаалт	16,380,000.00	7,862,595.20
210303	Цэвэр, бохир ус	110,946.00	677,902.65
210304	Байрны түрээс	38,573,863.17	27,222,830.47
2104	Хангамж, бараа материалын зардал	81,787,930.81	111,853,556.01
210401	Бичиг хэрэг	22,088,088.00	34,351,210.00
210402	Тээвэр, шатахуун	28,400,000.00	41,602,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,713,872.81	28,057,556.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,085,970.00	7,841,890.00
2105	Нормативд зардал	24,262,500.00	53,598,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,262,500.00	53,598,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,730,210.00	283,620,437.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,258,612.00	93,510,880.00
210602	Тавилга	0	39,499,900.00
210604	Урсгал засвар	54,471,598.00	150,609,657.00
2107	Томиллолт, зочны зардал	0	323,747,651.00
210701	Гадаад албан томиллолт	0	134,489,301.00
210702	Дотоод албан томиллолт	0	189,258,350.00

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	159,936,640.00	1,902,861,365.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,098,233.00	3,480,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,200,000.00	28,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	836,460.00	1,835,379,414.54
210804	Тээврийн хэрэгслийн татвар	555,504.00	975,538.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	97,650.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,486,000.00	15,894,000.00
210807	Газрын төлбөр	5,102,793.00	10,115,033.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.00	400,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,500,000.00	8,377,380.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	732,519,420.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	730,869,420.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	1,650,000.00
212	ТАТААС	193,077,982,867.00	314,400,510,210.01
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	29,090,115,176.00	31,371,773,388.51
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	29,090,115,176.00	31,371,773,388.51
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	163,987,867,691.00	283,028,736,821.50
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	163,987,867,691.00	283,028,736,821.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142,217,242.00	2,169,063,095.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,607,222.00	130,275,233.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	101,197,222.00	89,900,833.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,410,000.00	40,374,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,610,020.00	2,038,787,862.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,806,000.00	2,031,757,062.01
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	12,804,020.00	7,030,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	247,588,108,401.67	61,509,835,408.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	159,122,334,401.67	150,448,561,658.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	159,122,334,401.67	150,448,561,658.00
2200	Дотоод эх үүсвэрээр	159,122,334,401.67	150,448,561,658.00
222001	Тоног төхөөрөмж	137,658,700,000.00	117,109,704,691.00
223001	Бусад хөрөнгө	21,413,636,491.67	33,338,856,967.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,997,910.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-159,122,334,401.67	-
250006	Бусад зардал	0	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	88,465,774,000.00	-88,938,726,250.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	957,002,250.00	89,422,776,250.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	89,422,776,250.00	484,050,200.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,114,008.39	0	55,701,588,795.75	56,206,702,804.14
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	505,114,008.39	0	55,701,588,795.75	56,206,702,804.14
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	207,310,742,847.11	207,310,742,847.11
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,114,008.39	0	263,012,331,642.86	263,517,445,651.25
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	15,980,000,000.00	15,980,000,000.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	505,114,008.39	0	278,992,331,642.86	279,497,445,651.25
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-140,797,016,730.50	-140,797,016,730.50
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	505,114,008.39	0	138,195,314,912.36	138,700,428,920.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	324,675,766,000.00	321,571,715,303.32	-3,104,050,696.68	99.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,675,766,000.00	321,571,715,303.32	-3,104,050,696.68	99.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,045,211,000.00	7,080,585,360.31	-2,964,625,639.69	70.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,409,215,000.00	4,110,938,634.98	-2,298,276,365.02	64.14
210101	Үндсэн цалин	2,597,838,000.00	2,128,183,371.40	-469,654,628.60	81.92
210102	Нэмэгдэл	1,461,533,000.00	873,104,412.00	-588,428,588.00	59.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,809,500,000.00	795,307,430.58	-1,014,192,569.42	43.95
210104	Урамшуулал	540,344,000.00	314,343,421.00	-226,000,579.00	58.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,037,401,900.00	492,756,095.58	-544,645,804.42	47.50
210201	Тэтгэврийн даатгал	705,433,300.00	343,499,824.74	-361,933,475.26	48.69
210202	Тэтгэмжийн даатгал	82,992,200.00	40,799,816.05	-42,192,383.95	49.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	66,393,700.00	21,504,158.29	-44,889,541.71	32.39
210204	Ажилгүйдлийн даатгал	16,598,400.00	17,096,976.29	498,576.29	103.00
210205	Эрүүл мэндийн даатгал	165,984,300.00	69,855,320.21	-96,128,979.79	42.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,180,700.00	40,615,586.20	-90,565,113.80	30.96
210301	Гэрэл, цахилгаан	15,000,000.00	4,852,257.88	-10,147,742.12	32.35
210302	Түлш, халаалт	28,800,000.00	7,862,595.20	-20,937,404.80	27.30
210303	Цэвэр, бохир ус	13,800,000.00	677,902.65	-13,122,097.35	4.91
210304	Байрны түрээс	73,580,700.00	27,222,830.47	-46,357,869.53	37.00
2104	Хангамж, бараа материалын зардал	113,896,800.00	111,853,556.01	-2,043,243.99	98.21
210401	Бичиг хэрэг	35,271,600.00	34,351,210.00	-920,390.00	97.39
210402	Тээвэр, шатахуун	41,762,200.00	41,602,900.00	-159,300.00	99.62
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,589,000.00	28,057,556.01	-531,443.99	98.14
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,274,000.00	7,841,890.00	-432,110.00	94.78
2105	Нормативт зардал	58,300,000.00	53,598,800.00	-4,701,200.00	91.94
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	58,300,000.00	53,598,800.00	-4,701,200.00	91.94
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	284,256,400.00	283,620,437.00	-635,963.00	99.78
210601	Багаж, техник, хэрэгсэл	98,011,500.00	93,510,880.00	-4,500,620.00	95.41
210602	Тавилга	39,704,700.00	39,499,900.00	-204,800.00	99.48
210604	Урсгал засвар	146,540,200.00	150,609,657.00	4,069,457.00	102.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,926,145,500.00	1,902,861,365.54	-23,284,134.46	98.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	3,480,000.00	-1,520,000.00	69.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	28,000,000.00	28,000,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,836,000,000.00	1,835,379,414.54	-620,585.46	99.97

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,500,000.00	975,538.00	-524,462.00	65.04
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	840,000.00	240,000.00	-600,000.00	28.57
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,105,500.00	15,894,000.00	-2,211,500.00	87.79
210807	Газрын төлбөр	10,200,000.00	10,115,033.00	-84,967.00	99.17
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,500,000.00	400,000.00	-1,100,000.00	26.67
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,000,000.00	8,377,380.00	-16,622,620.00	33.51
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,814,700.00	84,340,885.00	-473,815.00	99.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,164,700.00	82,690,885.00	-473,815.00	99.43
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,650,000.00	1,650,000.00	0.00	100.00
212	ТАТААС	314,491,083,600.00	314,360,854,710.01	-130,228,889.99	99.96
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	31,461,452,600.00	31,332,117,888.51	-129,334,711.49	99.59
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	31,461,452,600.00	31,332,117,888.51	-129,334,711.49	99.59
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	283,029,631,000.00	283,028,736,821.50	-894,178.50	100.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	283,029,631,000.00	283,028,736,821.50	-894,178.50	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,471,400.00	130,275,233.00	-9,196,167.00	93.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	139,471,400.00	130,275,233.00	-9,196,167.00	93.41
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал			0.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	97,471,400.00	89,900,833.00	-7,570,567.00	92.23
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,000,000.00	40,374,400.00	-1,625,600.00	96.13
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.00	0.00	0.00
222001	Тоног төхөөрөмж		0.00	0.00	0.00
223001	Бусад хөрөнгө		0.00	0.00	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	324,675,766,000.00	330,998,942,870.32	6,323,176,870.32	101.95
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		0.00	0.00	
310001	Улсын төсвөөс санхүүжих		0.00	0.00	
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	320,610,557,400.00	315,474,509,641.31	-5,136,047,758.69	98.40
320001	Орон нутгийн төсвөөс	320,610,557,400.00	315,474,509,641.31	-5,136,047,758.69	98.40
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,065,208,600.00	15,524,433,229.01	11,459,224,629.01	381.89
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,792,759,700.00	15,356,570,520.01	11,563,810,820.01	404.89
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	272,448,900.00	167,862,709.00	-104,586,191.00	61.61
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		89,422,776,250.00	89,422,776,250.00	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		484,050,200.00	484,050,200.00	100.00

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			0.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
610002	Төсвөөс гадуур байгууллага			0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	350	153	-197.00	43.71
620001	Удирдах ажилтан	49	27	-22.00	55.10
620002	Гүйцэтгэх ажилтан	301	126	-175.00	41.86
620003	Үйлчлэх ажилтан				

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

Код	Үзүүлэлт	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,011,581,686.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,011,581,686.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	971,926,186.92
2107	Томилолт, зочны зардал	323,747,651.00
210701	Гадаад албан томилолт	134,489,301.00
210702	Дотоод албан томилолт	189,258,350.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	648,178,535.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	648,178,535.92
212	ТАТААС	39,655,500.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	39,655,500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,011,581,686.92
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,011,581,686.92
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	381,778,018.97
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	590,148,067.95
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,655,600.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,059,964.0 мянган төгрөгийн 11 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны орлого дансанд нэр данс зөрүүтэй, алдаатай 21,332.4 мянган төгрөгийн гүйлгээ орж ирснийг буцаан олгохдоо үндсэн үйл ажиллагааны орлого данс бууруулж алдаатай бүртгэсэн;
- Туслах үйл ажиллагааны орлого дансанд хамаарах 20,450.0 мянган төгрөгийн орлогын төрлийг үндсэн үйл ажиллагааны орлого дансанд алдаатай бүртгэсэн;
- Юутонг автобусны барьцааны дансанд байршуулсан 1,147,731.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг "Туслах үйл ажиллагааны орлого" дансанд орлого зөвшөөрч алдаатай бүртгэсэн;
- Тус байгууллагын ажилтан Б.Одгэрэлд олгосон ээлжийн амралтын илүү олгосон 904.3 мянган төгрөгийг буцаан дансанд төвлөрүүлснийг туслах үйл ажиллагааны орлого дансаар зөвшөөрч алдаатай бүртгэсэн;
- Баяр наадмын үйл ажиллагаатай холбоотойгоор нийтийн тээврийн үйлчилгээний компанид Нийслэлийн засаг даргын тамгын газраас олгосон 126,716.3 мянган төгрөгийн төлбөрийг дамжуулан олгохдоо зардалд бүртгэж үр дүнг бууруулж алдаатай бүртгэсэн;
- Нийтийн тээвэр үүсэн байгуулагдсаны 55 жилийн ойн арга хэмжээнд зориулж НЗДТГ-с нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон 54,790.0 мянган төгрөгийн үлдэгдэл болох 7,030.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэхдээ орлого данс бууруулах бичилт хийж алдаатай бүртгэл хийсэн;
- Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 3-р бүлэгт заасан "Цалингийн бүртгэл"-ийг мөрдөөгүйгээс Цалингийн өглөг, цалингийн зардал данс 127,491.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Ажилчдын Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжээр НД-с орж ирсэн 24,460.5 мянган төгрөгийг олгохдоо данс буруу сонгон хэрэглэж "Цалингийн өглөг" дансанд алдаатай бүртгэсэн;
- Бараа материалын "Бичиг хэрэг", "Сэлбэг хэрэгсэл" дансны 2,820.4 мянган төгрөгийн зарцуулалтыг "Акталсан бараа материал" ангилалд алдаатай бүртгэсэн;
- Тэнүүн огоо ХХК-с өр барагдуулах ажлын хүрээнд гаалиар оруулж ирсэн нэгж үнэ 218.6 сая төгрөгийн үнэ бүхий 50 автобусны Гааль, НӨАТ-ын татварыг тухайн байгууллага шилжүүлснийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа Бараа материалын дансны бусад хөрөнгө/ нөөц/ дансанд 1,813,767.5 мянган төгрөгөөр алдаатай бүртгэсэн;
- Тэнүүн огоо ХХК-наас 2023 онд хүлээн авсан дунд оврын 50 ш автобусыг 2024 оны ТӨБЗГ-ын 204 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/901, А/543 захирамжийн дагуу байгууллагуудад шилжүүлэхдээ дээрх шийдвэрт заасан өссөн дүнгээр зарлагдаж үнийн зөрүү үүссэнийг бараа

материалын дансанд 767,257.7 мянган төгрөгөөр олзоор тусгаж алдаатай бүртгэсэнг залруулсан.

Аудитаар нийт 4,112,437.2 мянган төгрөгийн 6 зөрчил¹ илэрснээс 3,729,876.4 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 382,515.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй нийт 5,263,232.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,610,933.0 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Байгууллагын авлагын дансанд бүртгэлтэй нийт 78 харилцагчийн 197,551,587.5 мянган төгрөгийн авлага байгаагаас 36 харилцагчтай холбоотой 3,105,622.9 мянган төгрөгийн авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Тухайн зөрчил 2022 оны санхүүгийн аудитаар илэрсэнд зөрчил арилгах албан шаардлага, 2023 оны санхүүгийн аудитаар давтан гарсанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн боловч зөрчлийг арилгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өр төлбөрийн тооцоог нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Байгууллагын хэрэгцээнд худалдан авсан үндсэн хөрөнгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", Монгол улсын засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг" гэж заасантай нийцээгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд боловсруулаагүй, төсвийн ерөнхийлөн захирагчид цахим системээр илгээгээгүй, худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тендерт шалгарсан Юүтонг бус ХХК-с нийлүүлсэн 600 ширхэг нийтийн тээврийн автобусыг оруулж ирэхтэй холбоотой жолооч нарт ажлын хөлс олгохдоо 17,560.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаж олгоогүй, цахимаар е-баримт бүртгүүлээгүй, татварт тайлагнаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.4. д “Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ.” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг суутгаагүй, тайлагнаагүй зөрчлийг зогсоож, цаашид давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүллэв.

4. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/17 дугаар захирамж, Нийтийн тээврийн автобус нийлүүлэх НЗДТГ/202310014 дугаартай гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлаар томилолтоор явсан Д.Д-д 30,350.0, И.Т-т 63,294.3, нийт 93,644.3 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр шилжүүлсэн байна. Аудитын шалгалтаар тооцоо нийлж үзэхэд анхан шатны баримт бүрэн шаардлага хангахгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоол "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.10-д "Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримт материалын бүрдүүлэлтийг бүрэн хангаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүллэв.

5.2 Зөвлөмж

1.Цалин хөлстэй холбоотой

Илрүүлэлт: Ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг олгохдоо албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ур чадварыг холбогдох хууль журамд зааснаар бодитоор үнэлж, дүгнэхгүйгээр хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 1996 оны 63/104 тоот тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл

олгох нийтлэг журам"-ын 7-д "Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын "Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгохдоо албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнг бодитоор, үнэн зөв үнэлэх;

2. Зардалтай холбоотой

Илрүүлэлт: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/17 дугаар захирамж, Нийтийн тээврийн автобус нийлүүлэх НЗДТГ/202310014 дугаартай гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлаар Юүтонг бус ХХК -с автобус нийлүүлэхтэй холбоотой гарах зардлыг Нийтийн тээврийн бодлогын газарт шилжүүлсэн бөгөөд Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны А/16 тоот тушаалаар батлагдсан төсөвт зардлын хүрээнд "Мэргэн Од" ХХК-нд 2 удаа автобусны жолооч нарыг тээвэрлэх зардлыг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүйгээр төлбөр шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоол "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.10-д "Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримт материалын бүрдүүлэлтийг бүрэн хангах, цаашид энэ төрлийн зөрчлийг гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

ДД	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Үндсэн үйл ажиллагааны орлого дансанд нэр данс зөрүүтэй, алдаатай 21,332.4 мянган төгрөгийн гүйлгээ орж ирснийг буцаан олгохдоо үндсэн үйл ажиллагааны орлого данс бууруулж алдаатай бүртгэсэн	1	21,332.4			1	21,332.4	1	21,332.4				
2	Туслах үйл ажиллагааны орлого дансанд хамаарах 20,450.0 мянган төгрөгийн орлогын төрлийг үндсэн үйл ажиллагааны орлого дансанд алдаатай бүртгэсэн	1	20,450.0			1	20,450.0	1	20,450.0				
3	Юүтонг автобусны барьцааны дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг "Туслах үйл ажиллагааны орлого" дансанд орлого зөвшөөрч алдаатай бүртгэсэн	1	1,147,731.3			1	1,147,731.3	1	1,147,731.3				
4	Тус байгууллагын ажилтан Б.Одгэрэлд олгосон ээлжийн амралтын илүү олгосон 904.3 мянган төгрөгийг буцаан дансанд төвлөрүүлснийг туслах үйл ажиллагааны орлого дансаар зөвшөөрч алдаатай бүртгэсэн	1	904.3			1	904.3	1	904.3				
5	Нийтийн тээвэр үүсэн байгуулагдсаны 55 жилийн ойн арга хэмжээнд зориулж НЗДТГ-с нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон 54,790.0 мянган төгрөгийн үлдэгдэл болох 7,030.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэхдээ орлого данс бууруулах бичилт хийж алдаатай бүртгэл хийсэн байна.	1	7,030.0			1	7,030.0	1	7,030.0				

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

6	Баяр наадмын үйл ажиллагаатай холбоотойгоор нийтийн тээврийн үйлчилгээний компанид НЗДТГ-аас олгосон төлбөрийг дамжуулан олгохдоо зардалд бүртгэж үр дүнг бууруулсан	1	126,716.3			1	126,716.3	1	126,716.3				
7	Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 3-р бүлэгт заасан "Цалингийн бүртгэл"-г мөрдөөгүйгээс Цалингийн өглөг, цалингийн зардал данс зөрүүтэй бүртгэсэн	1	127,491.8			1	127,491.8	1	127,491.8				
8	Ажилчдын Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжээр НД-с орж ирсэн 24,460.5 мянган төгрөгийг олгохдоо данс буруу сонгон хэрэглэж "Цалингийн өглөг" дансанд алдаатай бүртгэсэн	1	24,460.5			1	24,460.5	1	24,460.5				
9	Бараа материалын "Бичиг хэрэг", "Сэлбэг хэрэгсэл" дансны 2,820.4 мянган төгрөгийн зарцуулалтыг "Акталсан бараа материал" ангилалд алдаатай бүртгэсэн	1	2,820.4			1	2,820.4	1	2,820.4				
10	Тэнүүн огоо ХХК-с өр барагдуулах ажлын хүрээнд гаалиар оруулж ирсэн нэгж үнэ 218.6 сая төгрөгийн үнэ бүхий 50 автобусны Гааль, НӨАТ-ын татварыг тухайн байгууллага шилжүүлснийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа Бараа материалын дансны бусад хөрөнгө/ нөөц/ дансанд 1,813,767.5 мянган төгрөгөөр алдаатай бүртгэсэн	1	1,813,767.5			1	1,813,767.5	1	1,813,767.5				
11	2023 онд Тэнүүн огоо ХХК-наас хүлээн авсан дунд оврын 50 ш автобусыг 2024 оны 4 сарын 25-ны өдрийн ТӨБЗГ-ын 204-тогтоол, Нийслэлийн ЗД-ын А/901, А/543 захирамжийн дагуу байгууллагуудад шилжүүлэхдээ дээрх шийдвэрт заасан өссөн дүнгээр зарлагдаж үнийн зөрүү үүссэнийг бараа материалын дансанд 767,257.7 мянган төгрөгөөр олзоор тусгаж алдаатай бүртгэсэн	1	767,257.7			1	767,257.7	1	767,257.7				
	ДҮН	11	4,059,964.0	0	0.0	11	4,059,964.0	11	4,059,964.0	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Байгууллагын Авлагын дансанд бүртгэлтэй нийт 78 Харилцагчийн 197,551,587.5 мянган төгрөгийн авлага байгаагаас 36 харилцагчтай холбоотой 3,105,622.9 мянган төгрөгийн авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	3,105,622.9			1	3,105,622.9							
Төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө бэлтгэхэд, мөн хэрэгцээний зардлын ангиллаар тус тус худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.	1	567,997.4			1	567,997.4							
Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/17 дугаар захирамж, Нийтийн тээврийн автобус нийлүүлэх НЗДТГ/202310014 дугаартай гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлаар томилолтоор явсан Д. Дөлгөөнд 30,350.0 мянган төгрөг, И.Төмөрбаатарт 63,294.3 мянган төгрөг, нийт 93,644.3 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр шилжүүлсэн.	1	38,741.1			1	38,741.1							

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Аудитын шалгалтаар тооцоо нийлж үзэхэд 38,741.2 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.												
Юүтонг бус ХХК-с нийлүүлж буй 600ш Нийтийн тээврийн автобусыг оруулж ирэхтэй холбоотой 574 жолооч нарт ажлын хөлс олгохдоо ХХОАТ-ын тухай хуулийн 25-р зүйлийн 25.4 зүйлийн дагуу татвар суутгаж олгоогүй, татварт тайлагнаагүй байна.	1	17,560.0			1	17,560.0						
Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/17 дугаар захирамж, Нийтийн тээврийн автобус нийлүүлэх НЗДТГ/202310014 дугаартай гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлаар Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны А/16 тоот тушаалаар батлагдсан төсөвт зардлын хүрээнд Мэргэн Од ХХК-нд 2 удаагийн үйлдлээр автобусны жолооч нарыг тээвэрлэх зардлыг анхан шатны баримтын бүрдэлгүй төлбөр шилжүүлсэн.	1	50,600.0					1	50,600.0				
Ур чадварын нэмэгдэл, Үр дүнгийн урамшууллыг албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ур чадварыг холбогдох хууль журманд зааснаар бодитоор үнэлж, дүгнэхгүйгээр хавтгайруулан олгосон.	1	331,915.8					1	331,915.8				
Дүн	6	4,112,482.2			4	3,729,921.4	2	382,515.8			0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Нийтийн тээврийн бодлогын газар нь Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 1,845,029,757,826.12 төгрөгийн 1189 мэдээлэл байршуулахаас 337,861,937,337.74 төгрөгийн 334 мэдээллийг байршуулаагүй байна.	1	337,861,937.3	1	337,861,937.3		
Дүн	1	337,861,937.3	1	337,861,937.3		